Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт:

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 10-00/02 дугаар “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын ажлын зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийв.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-д заасны дагуу томилогдсон комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан орон сууцны-8, шатахуун түгээх станцын-2, албан байгууллагын-1, бетон зуурмагийн үйлдвэрлэлийн-1, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын-3, хүнсний агуулахын-1, цэвэрлэх байгууламжийн-1, ерөнхий боловсролын сургууль-6, эмнэлгийн-2, олон нийт иргэний-5 барилга нийт 30 барилга байгууламжид хяналт хийхэд барилга байгууламжийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагатай 100 зөрчлийг илрүүлэн 95%-ийг арилгуулан, илэрсэн зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 1 аж ахуйн нэгжид 3 сая төгрөгийн торгох шийтгэл ноогдуулж бүрэн барагдуулсан.

Шалгалтын явцад орон сууцны 5 барилга, 2 сургуулийн спорт заалны дотоод орчинд дэгдэмхий органик бодис тодорхойлох шинжилгээг хийлгүүлэхэд дэгдэмхий органик бодисын агууламж стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

1 иргэн 24 аж ахуйн нэгж байгууллагын 30 барилга байгууламжийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан, 1 барилгад хугацаатай үүрэг даалгавар өгч, 29 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.

Тайлан гаргасан:

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч: Б.Тэмүүжин